

**“ХҮНСНИЙ НОГОО” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2019 оны жилийн эцсийн байдлаар)**

№	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл		
1.	“Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоол		Зорилго: Өрхийн тариалан эрхлэгч болон хүнсний ногооны төрөлжсөн аж ахуйн нэгж, хоршоог дэмжих замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын хэрэгцээгээ жилийн турш тогтвортой хангахад зорилго оршино.		
2.	Санхүүжилтийн эх үүсвэр		Улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт		
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа		Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Хугацаа: 2018-2022 он		
			Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Аймаг, нийслэлийн ХХААГ, ХААДС, Гадаадын төслүүд		
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		Зорилт 1. Хамгаалагдсан хөрсний тариаланг дэмжиж, таримлын нэр төрлийг олшруулж, нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэн өвөл, хаврын улиралд хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор тогтвортой хангаж, импортын хамаарлыг бууруулах; Зорилт 2. Дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлж, усалгаатай тариалангийн хэмжээ, агуулах, зоорийн багтаамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хувийн хөрөнгө оруулалтыг урамшуулах, шууд худалдааны сүлжээ, төрөлжсөн захыг дэмжин хөгжүүлэх; Зорилт 3. Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг дэмжиж, ирээдүйтэй болон нутагшсан сортыг туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлэн үрийн чанарыг сайжруулж, хангамжийг нэмэгдүүлэх; Зорилт 4. Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхийг сайжруулах.		
			Тухайн жилийн төсөв: Улсын төсвөөс 290.0 сая төгрөг; Орон нутгийн төсвөөс 2,118.5 сая төгрөг; Гадаадын төслөөс 2,259.6 сая төгрөг; Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 2,159.7 сая төгрөг; Нийт 6.63 тэрбум төгрөг.		
5.	Үзүүлэлт	Төсөв (Нийт шаардагдах зардал)	Төсөв (2019 он)		
			Гүйцэтгэл		Хувь
			290.0	290.0	100.0
Төсөл, хөтөлбөрийн зорилт:		Арга хэмжээний биелэлт			
6.	Зорилт 1.		Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн 79-81 дугаар хуудсыг үзнэ үү.		
	Зорилт 2.		Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн 81-85 дугаар хуудсыг үзнэ үү.		
	Зорилт 3.		Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн 85-86 дугаар хуудсыг үзнэ үү.		
	Зорилт 4.		Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн 86-90 дугаар хуудсыг үзнэ үү.		
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)		Өрхийн тариалан эрхлэгч болон хүнсний ногооны төрөлжсөн аж ахуйн нэгж, хоршоог дэмжих замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын хэрэгцээгээ жилийн турш тогтвортой хангах зорилготой “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, аймгуудад “Хүнсний ногоо” дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд 2018-2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж ХХААХҮ-ийн Сайдын 2018 оны 07 дугаар 25-ны өдрийн А-127 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж байна.		

		<p>Хөтөлбөр хэрэгжсэнээр 2019 онд хүнсний ногоо тариалдаг 804 аж ахуйн нэгж, 15949 иргэн 8418.6 га-д хүнсний ногоо тариалсан. Эдгээр хүнсний ногоо тариалсан аж ахуйн нэгжийн 33.7 хувь, иргэдийн 51.6 хувь нь шууд хөтөлбөрийн үр шимийг хүртсэнээр нийт 98,652.4 тонн хүнсний ногоо хурааж авсан байна. Хүнсний ногоо тариалагч аж ахуйн нэгж, иргэдийн тоо, тариалсан талбай, хураан авсан ургац зэрэг гол үр дүнгийн үзүүлэлтүүд буурах хандлагатай байна. Хөтөлбөрийн хүрээнд 2019 онд ХХААХҮ-ийн сайдын багц, “Хүнсний ногоо” дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хөрөнгө оруулалт, гадаадын төслөөс нийт 6.63 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний ерөнхий гүйцэтгэл 2 дахь жилийн байдлаар 88.2 хувиар дүгнэгдлээ. Өнгөрсөн жилийн үнэлгээнээс 21.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийг тогтвортой үргэлжлүүлэх тал дээр анхаарч ажиллах нь зүйтэй. Цаашид хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлж хэд хэдэн зорилтын хүрээнд заасан ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа ХХААХҮЯ-ны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээний санхүүжилт маш бага байна. Тухайн жилийн хэрэгжилтээс дүгнэхэд орон нутаг, хувийн хэвшил, гадаадын төслийн санхүүжилтээр тус төслийн дийлэнх хэсэг хэрэгжиж байгаа нь харагдаж байна. Үндэсний хөтөлбөрийн үр дүнг аймаг, сумдаар нэгтгэн тайлагнаж, тайланг сайтар боловсруулсан байна. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлд төсөв, санхүүжилт шаардагдахгүй ажлуудыг ХХААХҮЯ, аймгийн ХХААГ-уудын зүгээс өөрсдийн бололцоог дайчлан үр дүнтэй хэрэгжүүлсэн нь үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээний ажлын дүнгээс харагдаж байна.</p> <p>ЗӨВЛӨМЖ:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлд улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, 2. Хүнсний ногоо шинээр тариалах сонирхолтой аж ахуйн нэгж иргэдийг дэмжих, мэргэжилтэй ажилтан бэлтгэх чиглэлд ХХААХҮЯ-аас анхаарч бодлогоор дэмжих, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтыг хүнсний ногоо тариалах сонирхолтой бүлэг хоршоодыг дэмжих, туршлагатай ногоочдыг боловсруулах үйлдвэр байгуулах, хоршиж ажиллах чиглэлд зээлийн дэмжлэгт хамруулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, 3. Дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлж, усалгаатай тариалангийн хэмжээ, агуулах, зоорийн багтаамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хувийн хөрөнгө оруулалтыг урамшуулах, шууд худалдааны сүлжээ, төрөлжсөн захыг дэмжин хөгжүүлэх, Статистикийн албан ёсны мэдээлэлд хүнсний ногоог таримлын нэр төрлөөр оруулж, мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх ажлуудыг эрчимжүүлэх, 4. “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөнд 2020 оноос хэрэгжүүлж эхлэхээр тусгагдсан 2 арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэх чиглэлд анхаарах, холбогдох төрийн болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахыг тус тус зөвлөмж болгож байна. 				
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ холбогдох яамд, төрийн байгууллага, ХААДС, дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрүүд, олон улсын байгууллагууд, төрийн бус байгууллагууд, хэвлэл, мэдээллийн байгууллагууд, аймгуудын ХХААГ, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар хангалттай сайн ажилласан гэж дүгнэж байна.				
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт Хяналт-шинжилгээ, үнэлгээ (Зорилт, арга хэмжээний үнэлгээ)	Биелэлт дундаж 88.2	Зорилт 1 93.0	Зорилт 2 75.0	Зорилт 3 90	Зорилт 4 94.5
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ ... %				

“Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн арга хэмжээний хэрэгжилтийн тайлан

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2019 оны зорилгот түвшин	ХЭРЭГЖИЛТ	Үнэл -гээ
1. Хамгаалагдсан хөрсний тариаланг дэмжиж, таримлын нэр төрлийг олшруулж, нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэн өвөл, хаврын улиралд хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор тогтвортой хангаж, импортын хамаарлыг бууруулах;						
1	1.1. Өвлийн хүлэмжийн аж ахуйг байгуулахад хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлийн дэмжлэг үзүүлж, хот суурингийн хүн амыг жилийн турш шинэ ургацын ногоогоор хангах;	2018 - 2022	3,400.0		2019 онд ЖДҮДС 736.4 сая, хувийн хэвшил, ОУБ-ын 2663.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 18800 м2 буюу 1.8 га талбай бүхий өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулагдав.Тухайлбал: БНСУ-ын Гангвон мужийн 550.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Төв аймгийн Зуунмод суманд 1000 м2 гидропоник, Баянчандмань суманд Бизнес интернешнл маркет ХХК өөрийн хөрөнгөөр 2000 м2 шилэн, “Эко урьхан” ХХК нь Борнуур сумын 7200 м2 шилэн хүлэмжинд 600 сая төгрөг, Грийнярд ХХК Улаанбаатар хотын Хан-уул дүүрэгт 1000 м2, иргэн Чинзориг Сүхбаатар дүүрэгт 600 м2, Завхан аймгийн “Загасан нүд - Загастай” ХХК 600 м2, Баянхонгор аймагт 70 сая төгрөгөөр 36 м2, Хөвт харийн нуруу ХХК 250 м2, Баян-өлгий аймагт иргэн Баужан 35 сая төгрөгөөр 500 м2 хүлэмж сэргээн засварласан, Дорноговь аймагт 600 м2, Хэнтий аймгийн Жаргалтхаан суманд Солонгос улсын 96,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 600 м2, Хэрлэн сумын иргэн Д. Осоржамаа 240 м2, Өмнөговь аймгийн Гурвантэс суманд уул уурхайн хөрөнгө оруулалтаар 600 м2 өвлийн хүлэмжүүдийг барьж ашиглалтад оруулан тариалалт хийж ургацыг 540 тонноор нэмэгдүүлсэн.Мөн Засгийн газрын 2018 оны 324 дүгээр тогтоолоор өвлийн хүлэмжийн цахилгааныг хөнгөлүүлэхээр батлуулсан ба 2020 оны төсөвт 2.0 тэрбум төгрөг батлуулсан. Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг цахилгааны төлбөрийг хөнгөлөхөөр 137 аж ахуйн нэгж иргэний судалгааг ЭХЯ-нд хүргүүлэв.	100%
2	1.2. Орон нутагт зуны нийлэг хальсан хүлэмж байгуулахад зориулж хөнгөлөлттэй нөхцөлөөр дэмжлэг үзүүлж, таримлын нэр төрлийг нэмэгдүүлэх;	2018 - 2022	1,107.0		Улсын төсвийн 147 сая төгрөгийн санхүүжилтээр 2019 онд 120 м2 талбай бүхий 38 иж бүрдэл 4560 м2 хүнсний ногооны хүлэмжийг нийлүүлэв. УИХ-ын гишүүдийн багцаас болон орон нутгийн төсөв, иргэд, олон улсын байгууллагын 960 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 19830 м2 нийлэг хальсан хүлэмж нэмэгдсэн.Тухайлбал: Улаанбаатар хотод 3320м2, Булган аймагт Шинэ хөдөө төслийн хүрээнд 3232 м2, Баян-өлгий аймгийн Өлгий суманд орон нутгийн төсвөөр 192 м2, Баянхонгор аймагт орон нутгийн 160.0 сая төгрөгөөр 600м2, Сагсай суманд Адра төслийн 24.5 сая төгрөгөөр 920 м2, Хэнтий аймагт Дэлхийн Зөн ОУБын санхүүжилтээр 620 м2, Өмнө-говь аймагт Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн 300 сая төгрөгийн санхүүжилтээр 7660 м2,ногоочид өөрийн хөрөнгийн 14.8 сая төгрөгөөр 384 м2, Шаргалжуут рашаан сувилал өөрийн хөрөнгийн 10.0 сая төгрөгөөр 400м2, аж ахуйн нэгж иргэдийн хөрөнгөөр 2200 м2, Говьсүмбэр аймаг 216 м2, Ховд аймаг 3120м2, Хөвсгөл аймаг 286 м2 нийлэг хальсан хүлэмж ашиглалтад оруулсан байна. Хүлэмжинд тариалах таримлын нэр төрөл өмнөх оныхоос бууцай, цэцэгт байцаа, артишок, усан үзэм төрлөөр нэмэгдсэн байна.	100%

3	1.3. Хүлэмжинд мөөг, ашигт таримал, гүзээлзгэнэ тариалахыг дэмжиж, гидропоник болон босоо тавиурт усан орчинд ногоо ургуулах дэвшилтэт технологийг нэвтрүүлж, нэгжийн ургацыг нэмэгдүүлэх;	2018 - 2022		Улсын хэмжээнд 97 га хүлэмжинд Баянхонгор, Дорноговь, Хэнтий, Төв, Өмнөговь, Архангай, Увс аймаг, нийслэлийн СХД-н ногоочид гүзээлзгэнэ, мөөг, усан үзэм тариалсан. Үүний 1800м2 –тай хүлэмж нь гидропоник дэвшилтэт технологийг нэвтрүүлж байна. Нэгжийн ургацыг 2018-оны суурь төвшнөөс 5 хувиар нэмэгдүүлсэн байна.	100%
4	1.4. Хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээх, ургацын чанар, тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор таримлын ургалтын үеийн био, органик, эрдэс бордоог хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх;	2018 - 2022		Хөрсний үржил шим сайжруулах, ургацын тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 2019 онд Хөдөө аж ахуйг дэмжих сан /хуучнаар ТЭДС/-тай хамтран химийн бодис, бордооны хэрэглээг бууруулах хүрээнд ургалтыг дэмжих байгалийн гаралтай гумины бордоо 100.0 тн, ургамлын өсөлт идэвхжүүлэгч ургамлын гаралтай бэлдмэл 4.8 тн, биологийн бэлдмэл 12.5 тн тус тус нийлүүлэн тариаланчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох ажлыг зохион байгуулсан.	100%
5	1.5. Ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, зохистой дадал, шинэ технологийг нэвтрүүлэх замаар химийн бодисын хэрэглээг бууруулах;	2018 - 2022		Дархан-Уул, Булган, Сэлэнгэ, Төв, Өвөрхангай, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй эрхлэгчид, дээрх аймгуудын газар тариалан хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан “Ургамал хамгаалал, хөрсний үржил шимийн менежмент” сургалтыг НҮБ-ын ХХААБ-аас санхүүжүүлж буй “Монгол ногоо” төслийн 4 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн багтай хамтран 2 удаа зохион байгуулсан ба сургалтад нийт 130 хүн хамрагдсан. Монгол-Герман улсын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн баг, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран 2019 оны 06 сарын 18-21 –ны өдрүүдэд Дархан-уул аймагт “Ургамал хамгааллын зохистой дадлыг хэвшүүлэх сургагч багш бэлтгэх сургалт”-ыг зохион байгуулж гэрчилгээ олгов. Мөн төслийн багтай хамтран 2019 оны 06 сарын 28–ны өдөр Дархан-уул аймагт “Тариалангийн талбайн хөрсний менежмент бордох технологи” сэдэвт сургалтыг 06 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан. НҮБ-ын ХХААБ-аас санхүүжүүлж буй “Монгол ногоо” төслийн 4 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн багтай хамтран “Хөдөө аж ахуйн зохистой дадал”, Ургамал хамгааллын цогц арга” сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг 2019 оны 12 сард тус тус зохион байгуулсан. Мөн Хөдөө аж ахуйн зохистой дадлын талаарх эрх зүйн баримт бичгийн эмхтгэл, ургамал хамгааллын цогц арга, ургамал хамгааллын бодисын хэрэглээ зэрэг номуудыг боловсруулан хэвлэж тараасан.	100%
6	1.6. Хүнсний ногооны тариалалт, хураалт, хадгалалтын технологийг хөрс, бордоо, ургамал хамгаалал, сорт, усжуулалт, механикжуулалт, хадгалалт, тээвэрлэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй хамтад нь авч үзэн цогцоор нь боловсруулж тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид зөвлөмж болгон хэрэгжүүлэх;	2018 - 2022		Хөрс, бордоо, ургамал хамгааллын чиглэлээр хөнөөлт организмыг таних каталог 100 ширхэг, тэмцэх заавар, зөвлөмж 100 ш, зурагт хуудас 50 ширхэг, ургамал хамгааллын цогц арга, ургамал хамгааллын бодисын хэрэглээ, 100ш тус тус хэвлүүлсэн ба хүнсний ногооны тариалалт, хураалт, хадгалалтын технологийг хөрс, бордоо, ургамал хамгаалал, сорт, усжуулалт, механикжуулалт, хадгалалт, тээвэрлэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй хамтад нь авч үзэн цогцоор нь багтаасан Газар тариалангийн систем номыг 1000 ширхгийг боловсруулан хэвлүүлж тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид зөвлөмж болгон тараасан.	100%
7	1.7. Хүнсний ногоог хатаах, хөлдөөх, хуурайшуулах дэвшилтэт технологийг нутагшуулах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн	2018 - 2022		Хүнсний ногоог хатаах, хөлдөөх, хуурайшуулах дэвшилтэт технологийг нутагшуулах, шинээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр Монгол ногоо төслийн болон бусад төслүүдийн хүрээнд сургалт, тоног төхөөрөмж нийлүүлэх, орон	70%

	үйлдвэрлэх туршиж, нэвтрүүлэхэд үзүүлэх;	технологийн үйлдвэрлэлд дэмжлэг			нутагт түгээх ажлууд хийгдлээ. Үүнд: Баянхонгор аймаг хүнсний ногоог дахин боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнд Германы хамтын ажиллагааны ЭТИС хөтөлбөрийн хүрээнд 15 сая төгрөгийн буцалтгүй тусламжаар хоногт 50 кг хүнсний ногоо хатаах тоног төхөөрөмж олгож үйлдвэрийн байр барьсан, Дархан-уул аймаг сум хөгжүүлэх сангаас 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж Буянда хоршоо нь ногоо нөөшлөх цехийг ашиглалтанд оруулж луувангийн шүүс болон хүнсний ногооны 5 төрлөөр боловсруулах цехийг ашиглалтад оруулж, 8 хүнийг байнгын ажлын байраар хангах үйл ажиллагааг эхлүүлсэн. Монгол ногоо төслийн хүрээнд 10.0 сая төгрөгийн үнэ бүхий хүнсний ногоо дахин боловсруулах тоног төхөөрөмж, 28.0 сая төгрөгийн үйлдвэрлэлийн байр төслөөс сум хөгжүүлэх сангаас 10.0 төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлснээр хүнсний ногоо дахин боловсруулах цех шинээр байгуулагдаж 10 хүнийг байнгын ажлын байр бий болж 8 төрлийн хүнсний бүтээгдэхүүн боловсруулж зах зээлд нийлүүлж эхлээд байна. Дорноговь аймгийн Сайншанд сумын иргэн 10 сая төгрөгөөр ногоо нөөшлөх цех, Өмнөговь аймаг ногоочин Х.Уранчимэг нь хатаах төхөөрөмжийг Монгол төслөөс авч уг технологиор 1000 кг хүнсний ногоо зах зээлд борлуулсан.	
8	1.8. Статистикийн албан ёсны мэдээлэлд хүнсний ногоог таримлын нэр төрлөөр оруулж, мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх.	2018 - 2022			Хүнсний ногооны 10 нэр төрлийн таримлаар яамны дотоод мэдээллийг аймгуудаас авч нэгтгэж мэдээллийн сан үүсгэж байна. Үндэсний статистикийн хороо /ҮСХ/-той хамтран газар тариалангийн маягтыг шинэчлэх ажлын хүрээнд ургамлын генетик нөөцийн мэдээний маягтад хүнсний ногооны талаарх мэдээллийг авч байхаар оруулсан. Цаашдаа ҮСХ-той Статистикийн албан ёсны мэдээлэлд хүнсний ногооны /таримлын нэр төрлөөр/ талаарх мэдээллийн тоо хэмжээ, чанарыг нэмэгдүүлэн, мэдээллийн санг сайжруулах талаар хамтран ажиллахаар тохиролцоод байгаа болно.	70%
Зорилт-1-ийн дундаж үнэлгээ					93.0	
2. Дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлж, усалгаатай тариалангийн хэмжээ, агуулах, зоорийн багтаамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хувийн хөрөнгө оруулалтыг урамшуулах, шууд худалдааны сүлжээ, төрөлжсөн захыг дэмжин хөгжүүлэх;						
9	2.1. Хүнсний ногоо үйлдвэрлэгчийн захиалгаар бага, дунд оврын трактор, түүнд зориулсан чиргүүлдүүжин машин, мотоблок болон түүнд сольж угсардаг үрлэгч, арчлах, хураах техникийг нийлүүлэх ажлыг зохион байгуулах;	2018 - 2022			Монгол ногоо төслийн хүрээнд 86,3 сая төгрөгөөр саримсны гар үрлэгч 5 ш, сонгины ухагч 3ш, сонгины үрлэгч 3ш, 2 мөрний манагч, сийрүүлэгч 3ш, 4 мөрний манагч, сийрүүлэгч 3ширхэг, Завхан аймаг орон нутгийн төсвөөс 80.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар МТЗ-82 трактор 1ш, анжис 1ш, төмс хураагч 1 ширхэг, Дэлхийн зөн ОУБ-аас 12.5 сая төгрөгөөр 2 мөрний төмс хураагч 1 ширхэг нийлүүлсэн. Баянхонгор: Орон нутгийн сангийн 34.0 сая төгрөгөөр хүнсний ногооны 2 иж бүрдэл техник, иргэд 0.6 сая төгрөгөөр 2 үрлэгч, Дархан-уул аймаг техникийн түрээсээр иргэдийн 93 га газрыг боловсруулж өгсөн байна. Дархан-уул аймгийн Орхон сумын экстейншин төвд техникийн түрээсээр 43.7 га, Сэлэнгэ аймгийн Мандал сумын экстейншин төвд 10.5 га талбайд, Төв аймгийн Борнуур сумын экстейншин төвд 52.6 га-д, Дорнод Экстейншин төвд 3 га-д хөрс боловсруулах, сийрүүлэх, ургамал хамгааллын бодис цацаж өгсөн.	70%
10	2.2. Хүнсний ногоог ялгаж дугаарлах, сортлох, савлах төхөөрөмж, гар багажны хангамжийг сайжруулах;	2018 - 2022	63.8		Дорнод аймагт гадаадын төсөл хөтөлбөрүүдээс 63.8 сая, төгрөгийн өртөг бүхий хүнсний ногоо хуурай цэвэрлэх болон сортлох тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн.	70%

11	2.3. Өрхийн тариалан эрхлэгчид сайн дураараа хорших, хуулийн этгээд байгуулах, нэгдсэн байдлаар техник, тоног төхөөрөмжийг худалдан авахад нь санхүү, эрх зүйн зөвлөмж болон зээл, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;	2018 - 2022	693.9		Увс аймгийн Улаангом сум, Төв аймгийн Борнуур сум, Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Дархан Уул аймгийн Орхон сум АХБ-аас хэрэгжих төслийн нээлтийг зохион байгуулсан ба нийт 600 гаруй орон нутгийн иргэдэд мэдээлэл өгсөн. Төсөл хэрэгжих 4 сумын засаг дарга нар нээлтийн хуралд оролцож сумын хүнсний ногооны үйлдвэрлэл, орон нутгийн онцлог болон төслийг амжилттай хамтран хэрэгжүүлэх талаар мэдээлэл хийв. Шалгуур үзүүлэлтүүдийн шаардлагыг хангасан Дархан Уул аймгийн Орхон сумын 10 бүлэг, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 10 бүлэг, Увс аймгийн Улаангом сумын 9 бүлэг, Төв аймгийн Борнуур сумын 10 ногоочдын бүлгүүдийг сонгон шалгаруулж, дэлгэрэнгүй мэдээллийг АХБ-нд хүргүүлсэн бөгөөд АХБ-наас төсөлд хамрагдах 39 бүлгийн 306 өрхийн зөвшөөрөл ирж, төсөлд хамрагдах болсныг баталгаажуулсан. Төв аймгийн Борнуур, Жаргалант, Батсүмбэр мөн Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол, Хушаат сумын 120 гаруй ногоочдын санаачилгаар “Цэвэр хөрсний шим” дундын хоршоо үүсгэн байгуулагдсан. Хоршоо нь гарал үүсэл тодорхой, шинжилгээний бичгээр баталгаажсан төмс, хүнсний ногоог гэрээт үйлдвэрлэлийн зарчмаар сүлжээ дэлгүүр, нийтийн хоолны газар зэрэг 5 аж ахуйн нэгж, байгууллагын 17 салбарт нийлүүлж байна. 2019 оны 11 сарын байдлаар 460 сая төгрөгийн борлуулалт буюу нийт 363 тонн ногоог нийлүүлжээ. Үүний үр дүнд ногоочдын ашиг 20% иар нэмэгдэж байна. Баянхонгор аймаг “Эрүүл жимсийг өөрийн хашаандаа” 90 өрх хамрагдан төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалан ургуулах 146.0 сая төгрөгийн төслийг хэрэгжүүлж байна. Хэнтий аймаг ногоочдын дундын хоршоо байгуулан хүлэмж 1, дунд оврын трактор 1, бусад дагалдах хэрэгсэл нийт 87.9 сая төгрөгийн техник хэрэгсэл олгосон.	70%
12	2.4. Хүнсний ногооны үйлдвэрлэлд ажиллаж байгаа залуу гэр бүл, залуучуудад гарааны болон санхүүгийн дэмжлэг олгож, ажлын байртай болгох, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;	2018 - 2022	45.0		Хоршоолсон хэлбэрээр хүнсний ногоо эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах нь төсөлд 39 бүлгийн 306 өрх байгаа ба үүнээс 37,9% нь өрх толгойлсон болон зорилтот бүлгийн өрхүүд хамрагдсан байна. Мөн төсөлд хамрагдах нийт 39 бүлгийн 1048 өрхийн гишүүдийн 53.5% буюу 561 гишүүн нь эмэгтэйчүүд, 55 өрх толгойлсон, эмзэг бүлгийн өрх байна. Нийт ногоочдын бүлгийн ахлагчдын хувьд, 30,7% буюу 12 эрэгтэй ахлагчтай байна. Ил талбайн болон хүлэмжийн хүнсний ногооны үр 4 сумын ногоочдын бүлгүүдэд шар луувангийн үр, шар манжингийн үр, хүрэн манжингийн, бөөрөнхий сонгины үр, урт сонгины үр, бөөрөнхий сонгины төл үр зэрэг нийт 757 кг үрийг түгээсэн. Ногоочдын бүлгүүд төслөөс санхүүжсэн үрээр нийт 234,8 га-д хүнсний ногооны тариалалт хийж, 2553,7 тн ургац хураан авсан. Орхон аймагт сум хөгжүүлэх сангийн зээлд 2 иргэний хүлэмжийн аж ахуйн төсөлд 25.0 сая, бордооны төсөлд 10.0 сая, артишокны тариалалт, зоорийн аж ахуйд 10.0 сая төгрөг нийт 45 сая төгрөгийн зээлийн дэмжлэгт залуу 5 иргэн хамруулсан байна.	70%
13	2.5. Хүнсний ногоо тариалахад тохирсон эрчим хүчний зарцуулалт багатай, ус хэмнэлтэй зарцуулдаг, байгаль орчинд халгүй, хямд төсөр усалгааны арга болох	2018 - 2022	27.0		“Шинэ хөдөө Булган” төслийн хүрээнд төмс, хүнсний ногооны услах зориулалт бүхий 15 ширхэг буюу 150 га услах хүчин чадал бүхий 10 га-ийн усалтын системийг 12 суманд суурилуулсан. Орхон аймаг Баян-Өндөр сум орон нутгийн төсвөөс 27.0 сая төгрөгөөр	70%

	дуслын усалгаа, хөрсөн дотроос нэвчүүлэх усалгаа зэрэг дэвшилттэй технологи нэвтрүүлэх;				ногоочдод 2 ширхэг худаг, ХХХНЭЗӨМАС төслийн хүрээнд Увс аймгийн Улаангом сумын үр үржүүлэгч нарын талбайд 3 ширхэг худаг гаргасан.	
14	2.6. Гэрийн болон үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсний ногооны стандартыг боловсруулж мөрдүүлэх;	2018 - 2022			Хүнсний ногооны стандартууд шинээр боловсруулах, шинэчлэх стандартуудад хийгдсэн шинжилгээний дүнд 2018 онд 52 стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаагийн 25 стандартад нэмэлт өөрчлөлт оруулах, 5 стандартыг хүчингүй болгох, 30 стандарт шинээр боловсруулах шаардлага байна гэсэн дүгнэлтийг ажлын хэсэг гаргасан. Үүний үр дүнд Стандарт, хэмжилт зүйн үндэсний зөвлөлийн 2018 оны 2-р сарын 22-ны өдөр гарсан тогтоолд дурдсаны дагуу Монгол ногоо төсөл хүнсний ногооны 9 стандартын төсөл шинээр боловсруулах, 1970 оноос хойших 19 стандарт шинэчлэх ажлыг зохион байгуулах, техникийн хороогоор хэлэлцүүлж, батлуулахаар хэлэлцүүлэг хийж эцэслэн боловсруулсан. Энэ ажлын хүрээнд нийт 26 стандартыг төрлөөр нь багцлан Стандартчиллын үндэсний зөвлөлийн Хүнсний стандартчиллын техникийн хороогоор 2019 онд 18 стандартыг хэлэлцүүлсэн. Ургамал газар тариалангийн хүрээлэнгээс СХЗҮ-ний газарт хэлэлцүүлсэн байцаа, сармисны стандартыг батлуулсан.	70%
15	2.7. Услалтын системийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, дэд бүтцийг сайжруулах замаар ногоочдын бүлэг, хоршоодыг дэмжин нэгж талбайгаас авах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх;	2018 - 2022	1,490.6		БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих" төслийн хүрээнд "Усалгааны тоног төхөөрөмж, усалгааны хоолой олгох тухай" ХХААХҮ-н сайдын 2019 оны А-107 тушаалаар төмс хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлдэг Дархан-уул аймгийн иргэн Д.Хадбаатарт өөрийн хүсэлт, услалтын системийн зураг төслийн дагуу 181.2 сая төгрөгийн үнэ бүхий 75 га талбайг услах хүчин чадалтай бороожуулагчийг 12 жилийн хугацаатай зээлээр олгосон ба ашиглалтад оруулсан. Сүхбаатар аймагт Баруун-Урт сум 1 га-н бороожуулагч 4 сая төгрөгөөр, Онгон сумдад агропаркыг өргөжүүлэх 1 га талбайн намираа усалгааны системийг 5.4 сая төгрөгөөр байгуулсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Булган сум 500.0 сая төгрөг, Үенч сум 400.0 сая төгрөг, Ховд сум 200.0 сая төгрөг, Зэрэг сум 200.0 сая нийт 1.3 тэрбум төгрөгөөр 767 га услалтын системийг сэргээн засварлах ажил хийгдэж сум орон нутагт хүлээлгэн өгсөн.	100%
16	2.8. Инженерийн хийцтэй томоохон услалтын систем бүхий иргэн, аж ахуйн нэгж таримлын сэлгээндээ хүнсний ногоо тариалах санаачилгыг дэмжих замаар үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх;	2018 - 2022	762.5		2019 онд төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд нийт 57.2 га шинээр ашиглалтад оруулсан. Үүнд: Өмнөговь аймаг "Баяндалай сумын Наран, Даланзадгад сумын Далан, Ханхонгор сумын Шавартайн услалтын системүүдийн ашиглалтын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд орон нутгийн төсвөөс 562.5 сая төгрөгөөр 27.2 га, Орхон аймгийн Хан угтаал ХХК 200.0 сая төгрөг 50 га талбай инженерийн хийцтэй услалтын системтэй болсон.	100%
17	2.9. Байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй хөргөлт, халаалтын технологитой стандарт бүхий зоорийн аж ахуйг нэмэгдүүлэх;	2018 - 2022			Ховд аймгийн Жаргалант суманд 967 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хүнсний ногооны 1000 тн багтаамжтай зоорь ашиглалтад оруулсан. Завхан аймгийн "Завхан солонго" хоршоо 80 тн, "Загасан нүд-Загастай" ХХК 200 тн, МХЗТФХ ТББ нь 1000 тн багтаамж бүхий механикжсан зоорь бүхий хүнсний ногоо хадгалах зоорь барьж ашиглалтад оруулсан. Монгол Улсад нийтээр даган мөрдөж байгаа Барилгын норм ба дүрмүүдээс төмс, хүнсний	70%

				ногооны зоорь байгуулахад шаардлагатай дүрэм, тухайн баримт бичгээр зөвшөөрсөн гадаадын стандарт, норм ба дүрэм, төмс, хүнсний ногоог хадгалалтад хүлээн авах, хадгалах арга, хадгалалтын үеийн технологийн горим, хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлал зэрэг баримт бичгүүдийг судлан түүвэрлэж эмхтгэн нэгтгэх, хэвлийн эх бэлтгэж хэвлэх үйлчилгээг IFAD Олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэхээр ажиллаж байна.	
18	2.10. Таримлын төрөлд зохицсон зориулалтын зоорь, агуулах байгуулах иргэн аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлж, импортыг бууруулах;	2018 - 2022	2,079.5	Улсын хэмжээнд 3266 ширхэг буюу 136.8 мянган тонн багтаамж тн -оор зоорь нэмэгдэж байригдсан байна. Үүнд: Баянхонгор аймагт Германы GIZ байгууллагын ЭТИС хөтөлбөрийн хүрээнд Номгоны андууд ТББ-д 50 тн багтаамжтай зоорийг 15 сая төгрөг, Өлзийт сум 5 сая төгрөгөөр 20 тн багтаамжтай зоорь, Баянлиг сумд 100 тн-ийн багтаамжтай зоорийг иргэн С.Чулуун, Б.Төртөгтох нар өөрсдийн 15 сая төгрөгийн хөрөнгөөр, Баянцагаан сум 30 тн-ийн багтаамжтай ОНХСангийн болон иргэдийн өөрийн хөрөнгө оруулалтаар 9 сая төгрөгөөр барьсан. Хэнтий аймаг энгийн болон нүхэн зоорь барьсан иргэд нөхөрлөл, хоршоо, бүлэгт жил бүр 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэж нийт 10 иргэнд 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Орхон аймаг Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас “Арвин туруун” ХХК-ны 58.7 сая төгрөгөөр шинээр зоорь барьсан. Жаргалант сумын иргэн зээлийн батлан даалтын сангаас 100.0 сая төгрөгийн зээлээр зоорь байгуулсан. Өмнөговь аймаг төмс, хүнсний ногооны 200 тн багтаамж бүхий механикжсан зоорийг орон нутгийн төсвийн 499.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьсан. Сүхбаатар аймаг улсын төсвийн 400 сая төгрөгөөр 500 тн багтаамжтай зоорь, Ховд аймаг улсын төсвийн 967.8 сая төгрөгөөр 1000 тн багтаамжтай зоорийг тус тус ашиглалтад оруулсан.	70%
19	2.11. Хүнсний ногоо тариалагчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ чанар, стандартад нийцүүлэн зах зээлд нийлүүлэх, борлуулалтын дотоод сүлжээ бий болгох боломжийг бүрдүүлэх;	2018 - 2022		ХХААХҮЯ-ны захиалгаар Улаанбаатар хотод 16.0 мянган тонн багтаамжтай “Төмс, хүнсний ногоо жимс, жимсгэнэ, махны хадгалалт борлуулалтын цогцолбор төв” байгуулахаар Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт 10 га газрыг шийдвэрлүүлж, төслийн техник эдийн засгийн үндэслэл батлуулж, байгаль орчны үнэлгээ хийсэн. 17 аймагт ХАА-н захаас гадна тусгайлсан ногооны төрөлжсөн захыг ажиллуулж эхэлсэн, нийслэлийн 9 дүүргийн 70 гаруй цэгт 08 сарын 05-өдрөөс 11 дүгээр сарын 1 хүртэл төмс, хүнсний ногооны худалдааг зохион байгуулж хэрэгжүүлсэн нь борлуулалтыг 20-30 хувиар өсгөсөн үр дүнтэй ажил болсон. Монгол ногоо төслийн хүрээнд гарал үүсэл тодорхой, шинжилгээний бичгээр баталгаажсан төмс, хүнсний ногоог гэрээт үйлдвэрлэлийн зарчмаар Номин супермаркет, Модерн номадс ресторан, Сонгдо эмнэлэг зэрэг 5 аж ахуйн нэгж, байгууллагын 17 салбарт жилд 400 тн ногоо нийлүүлж 500 сая төгрөгийн борлуулалт хийж, үр дүнд нь ногоочдын ашиг 20% иар нэмэгдсэн.	70%
20	2.12. Хүнсний ногоо тариалагчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ чанар, стандартад нийцүүлэн зах зээлд нийлүүлэх,	2018 - 2022		Улаанбаатар хотод хадгалалтын хүчин чадал 16.0 мянган тонн багтаамжтай “Төмс, хүнсний ногоо жимс, жимсгэнэ, махны хадгалалт борлуулалтын цогцолбор төв” байгуулахаар Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны	70%

	борлуулалтын дотоод сүлжээ бий болгох боломжийг бүрдүүлэх;				нутаг дэвсгэрт 10 га газрыг шийдвэрлүүлж, төслийн техник эдийн засгийн үндэслэл батлуулж, байгаль орчны үнэлгээ хийгдсэн. 17 аймагт ХАА-н захаас гадна тусгайлсан ногооны төрөлжсөн захыг ажиллуулж эхэлсэн, нийслэлийн 9 дүүргийн 70 гаруй цэгт 08 сарын 05-өдрөөс 11 дүгээр сарын 1 хүртэл төмс, хүнсний ногооны худалдааг зохион байгуулж хэрэгжүүлсэн нь борлуулалтыг 20-30 хувиар өсгөсөн үр дүнтэй ажил болсон. Монгол ногоо төслийн хүрээнд гарал үүсэл тодорхой, шинжилгээний бичгээр баталгаажсан төмс, хүнсний ногоог гэрээт үйлдвэрлэлийн зарчмаар Номин супермаркет, Модерн номадс ресторан, Сонгдо эмнэлэг зэрэг 5 аж ахуйн нэгж, байгууллагын 17 салбарт жилд 400 тн ногоо нийлүүлж 500 сая төгрөгийн борлуулалт хийж, үр дүнд нь ногоочдын ашиг 20% иар нэмэгдсэн.	
21	2.13. Хүнсний ногооны борлуулалтыг төрийн худалдан авалт (боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, хууль сахиулах болон уул уурхай)-аар дэмжих бодлого, зохицуулалтын арга хэмжээ авах.	2018 - 2022			Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Эх оронч худалдан авалтын жил”-ийн хүрээнд дотооддоо үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг худалдан авах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх, техник технологийн шинэчлэл хийх, олон улсын стандартын шаардлагад нийцсэн зах зээлд өрсөлдөх чадвартай бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, худалдан авалтыг нэмэгдүүлэх хүрээнд дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай 14 бүлгийн 155 нэр төрлийн жагсаалтыг шинэчлэн Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор баталсан. Эдгээр бараа, бүтээгдэхүүнийг аливаа тендерийн үндсэн нөхцөл болгож, худалдан авах бодлогыг Засгийн газар баримтлахаар тогтсон. Хүнсний бүтээгдэхүүний бүлэгт шинэ буюу хөлдөөсөн, хатаасан төмс, хүнсний ногоо гэж нэмж оруулсан.	70%
Зорилт-2-ын дундаж үнэлгээ					75.0	
3. Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг дэмжиж, ирээдүйтэй болон нутагшсан сортыг туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлэн үрийн чанарыг сайжруулж, хангамжийг нэмэгдүүлэх;						
22	3.1. Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг үрийн аж ахуйн тогтолцооны дагуу нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, хяналтад оруулж, гарал үүсэл нь тодорхой, чанарын баталгаатай торгон, сортын болон эрлийз үр үйлдвэрлэж, борлуулах нөхцөлийг бүрдүүлэх;	2020 - 2021			Хугацаа болоогүй	Үнэлэх боломжгүй
23	3.2. Агроэкологийн нөхцөлийг харгалзан ногооны үр үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлэх, үр үржүүлэгчийн мэргэшлийн түвшин, дадлага туршлага, материаллаг баазын хангамж зэрэгт тулгуурлан үр үржүүлэхийг дэмжих;	2020 - 2021			Хугацаа болоогүй	Үнэлэх боломжгүй
24	3.3. Ногооны үр үйлдвэрлэл эрхлэгчдэд үрсэлгээ бойжуулах зориулалтын хүлэмжийн аж ахуйг байгуулахад нь дэмжлэг үзүүлэх;	2019 - 2021			Ногооны үр болон жимсний суулгаж үржүүлэх 10 ширхэг буюу 1200 м2 нийлэг хальсан хүлэмжийг тариалангийн төвийн бүсүүдэд олгосон. Төрөлжиж үрсэлгээ бойжуулах хүлэмжийг 30 хувийн урьдчилгаатай 4 жилийн лизингийн гэрээгээр олгох ХХААХҮ-н сайдын А-97 дугаар тушаалаар дэмжлэгийг 10 иргэнд олголоо. “Ургамал хамгааллын зохистой дадал”, “Таримлын үрсэлгээний чанар, тариалах	70%

					технологи, ургалтын үеийн арчилгаа, түгээмэл тархдаг өвчнийг ялган таних" сургалтыг Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сум, Булган аймгийн Булган, Могод, Хутагт-Өндөр сумдын 51 ногоочинд ХААШУОУНТ-өөс зохион байгуулсан.	
25	3.4. Хүнсний ногооны үрийн тариалан эрхлэгчдэд сэлгээний талбай нэмж олгох ажлыг зохион байгуулах;	2018 - 2022			Хүнсний ногооны үр болон үйлдвэрлэл эрхлэгч ногоочин нарт АХБ-аас санхүүжигдэх ХХХНЭЗӨАС төслийн хүрээнд Увс аймгийн Улаангом суманд 9 бүлгийн ногоочдод 20 га, үүний 1 га нь төслийн эзэмшилд, Дархан-уул аймгийн Орхон суманд 10 бүлгийн ногоочдод 1.2 га, Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 10 бүлгийн ногоочдод 3 га талбайг тус тус шинээр нэмж олгосон. Дорноговь аймаг 4 иргэнд төмс, хүнсний ногооны тариалан эрхлэх зориулалтаар 10 га газар олгосон байна.	100%
26	3.5. Ногооны шинэ сорт бүтээх, шинэ таримал турших, тэдгээрийн элит сортын баталгаат үр үржүүлгийг дэмжиж, шинжлэх ухаан, технологийн төслийг захирал эрдэм шинжилгээний байгууллагуудаар гүйцэтгүүлэх.	2018 - 2022			2019 онд Улсын сорт сорилтын зөвлөлөөр хүнсний ногооноос бууцайны "Матадор", цэсний "Чёрная красавица" сортууд нутагшсан сортоор, бөөрөнхий сонгины " Nongwoodaego", "Richhong", "Aruseu", "Biseul huang", "Goraenji" сортууд, лоолийн "Seminis SV7160 TC –F1", "TY candy f1" сортуудыг 2019 онд сорт сорилтод, лоолийн "TY CANDY-F1", "Seminis-Sv7160TC –f1" хэмхийн "Restina F1" сортууд нь ирээдүйтэй сортоор батлагдсан. 2017 оноос хойш голлох нэр төрлийн хүнсний ногооны хувьд 12 нутагшсан, 14 ирээдүйтэй сорт, 13 эрлийз ирээдүйтэй сорт шинээр батлагдаад байна. Дархан-уул аймгийн Орхон сумын экстейншин төвд 1 га талбайд 9 зүйлийн 9 сортын хүнсний ногоо, Сэлэнгэ аймгийн Мандал сумын экстейншн төвд 1.5 га талбайд 4 зүйлийн 5 сортын ногоо, Төв аймгийн Борнуур сумын экстейншн төвөд 0.6 га-д 3 зүйлийн 4 сорт ногоог тарьсан ба үйл ажиллагааны зардал Монгол ногоо төслөөс 23.6 сая төгрөгийг дэмжлэгээр олгосон. ХХААХҮЯ-ны захиалгаар хөтөлбөр эхэлсэн 2017-2019 онд шинжлэх ухаан, технологийн төслөөр "Хүнсний ногоо, төмсний селекци судалгаа, шинэ сортуудын үр үржүүлэг" 110 сая төгрөгөөр, "Монгол орны газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглаж байгаа усалтын тоног төхөөрөмжийн ашиглалт, технологийн үзүүлэлт, бүтээл, эрчим хүчний зарцуулалт, засвар техникийн үйлчилгээний норм, нормативийг тогтоох судалгаа" 58 сая, "Монгол орны газар тариалангийн төвийн бүсийн ургамал хамгааллын бодисын хэрэглээний мониторинг болон үлдэгдлийн судалгаа, тэдгээрийг саармагжуулах, эрсдлийн үнэлгээ хийх технологи" судалгааг 112 сая төгрөгийн санхүүжилтэйгээр тус тус хэрэгжүүлэхээр Ургамал газар тариалангийн хүрээлэнгээр гүйцэтгүүлэхээр санхүүжүүлж судалгаа шинжилгээний ажлыг эхлүүлсэн.	100%
Зорилт-3-ын дундаж үнэлгээ						90.0
4. Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхийг сайжруулах.						
27	4.1. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд ногоочин, техникийн ажилтан бэлтгэх гөрөлжсөн анги, сургалтын тоог нэмэгдүүлэх, суралцах сонирхолтой, сургуулиа төгсөөд ажиллах боломжтой залуучуудыг хөнгөлөлттэй нөхцөлөөр сургах, мэргэшүүлэх;	2018 - 2022			Арханагай, Дорноговь, Сүхбаатар, Өвөрхангай, Баян-өлгий, Сэлэнгэ, аймгийн МСҮТ-тэй хамтран газар тариалангийн үйлдвэрлэлд мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэж газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор хүлэмжийн аж ахуй фермер, хүнсний ногооны фермерийн аж ахуйн ангийг шинээр нээсэн. ХАА-н трактор комбайнчны мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг ХАА-н машины дилер компаниудыг түшиглэн явуулж байна.	70%

28	4.2. Салбарын эрдэмтэн, мэргэжилтнүүдийг гадаад орнуудын үр үйлдвэрлэх, хүлэмжийн аж ахуй, усалгааны шинэ техник, зоорийн тоног төхөөрөмжтэй танилцуулах, олон улсын үзэсгэлэнд оролцуулах, сургаж дадлагажуулах замаар хүнсний ногооны тариалалт, үйлдвэрлэлийн шинэ технологи эзэмшүүлэх;	2018 - 2022		Усалгааны шинэ техник, тоног төхөөрөмжийн судалгаа олон улсын форумд АХБ-ны санхүүжилтээр Индонез улсад яамнаас 3 мэргэжилтэн, БНСУ-д "органик газар тариалангийн хөгжил" сургалтад яамнаас 2 мэргэжилтэн, БНХАУ-ын худалдааны яам, ХХААХҮЯам хоорондын хамтын ажиллагааны хүрээнд ӨМӨЗО Тариалангийн их сургууль, ӨМӨЗО-ны хүлэмжийн аж ахуй, гидродоник орчинд хүнсний ногоо ургуулах чиглэлээр зохион байгуулсан мэргэжил дээшлүүлэх сургалтанд газар тариалан хариуцсан мэргэжилтэн хамруулж Хөх хот, Бугат, Баяннуур аймгийн туршлагыг судлуулсан ажилласан. Дорноговь аймаг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөн буйр аймгийн Хайлаар хотд зохион байгуулагдсан "Ногоон хөгжил" ОУ-ын үзэсгэлэн яармагт тус аймгаас 5 хүний төлөөллийг оролцуулж шинэ техник, технологи, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн үйлчилгээг сонирхон туршлага судлуулж хамтын түншлэлээ бэхжүүлэн ажилласан. Өмнөговь аймаг Япон улсад Булган сумын ногоочин Ц.Тогоосүрэн, Номгон сумын ногоочин Д.Мөнхбат, Ханхонгор сумын ногоочин Б.Насанбаяр, Даланзадгад сумын ногоочин Ж.Долгорсүрэн, Номгон сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн дарга Б.Одгэрэл нарыг туршлага судлуулах сургалтад тус тус хамруулсан. Мөн 15 сумын 43 газар тариалан эрхлэгчийг БНХАУ-ын ӨМӨЗ орны Баяннуур аймгийн газар тариалангийн салбарын үйл ажиллагаатай танилцуулах сургалтад хамруулсан.	100%
29	4.3. Хүн амд дотоодын хүнсний ногоог зохистой хэрэглэхийн ач тусыг ойлгуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах;	2018 - 2021		Монгол Улсын 21 аймгийн ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагддаг хүүхдүүдийн хоолны шим тэжээл, эрүүл мэндийн байдлыг хүнсний ногоогоор дамжуулан сайжруулах зорилгоор “Хүүхдийн хооллолт ба эрүүл мэнд” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад Нийслэлийн 9 дүүргийн төрийн өмчийн цэцэрлэгийн 231 тогооч, Сэлэнгэ, Ховд, Завхан, Увс аймгийн 265 цэцэрлэгийн тогоочид буюу нийт 491 тогооч хамрагдлаа. Үүний үр дүнд цэцэрлэгийн хоолны цэс шинээр 4-10 аар нэмэгдэх боломжтой боллоо.	100%
30	4.4. Хүнсний ногоо тариалах, арчлах, ургацыг хадгалах, боловсруулах технологи, арга ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж, сурталчлах ажиллагааг өргөжүүлэх;	2018 - 2021		"Хүнсний ногоо" эрхлэгчдийн анхдугаар улсын зөвлөгөөнийг Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулж, 200 ногоочдод "Хүнсний ногооны таримлын сортын каталог, технологийн зөвлөмж ном, Тариаланчид сэтгүүл, гарын авлага өгөв. "Атар 60" газар тариалангийн техник, технологи, ажиллаж буй тариаланчид, төр засгаас гарч байсан шийдвэрийг тусгасан баримтат киног акт, тэмдэглэлээр хүлээн авч, UBS телевизээс бэлтгэсэн уран сайхны киноны нээлтийг баярын өдрүүдийн арга хэмжээгээр 1000 гаруй төлөөлөгчдөд үзүүлэх арга хэмжээг зохион байгуулав. Газар тариалангийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа тэргүүний тариаланчдаасаа бүсийн төлөөлөл болгон 9 хүнийг сонгож оролцуулан "Атар 60-ын баатрууд" нэвтрүүлгийг МҮОНТ-тэй хамтран зохион байгуулав. Атар 60-ын баатраар Төв аймгийн Жаргалант сумын ногооны "Дэлгэр уянга" ХХК-ийн захирал Л.Болдбаатарыг шалгаруулж дагнасан нэвтрүүлэг бэлтгэж МҮОНТ-ээр дамжуулан нийтийн хүртээл	100%

				болгон цацаж алдаршуулав. “Баатруудаа алдаршууля” 9 удаагийн нэвтрүүлэг, “Хөдөлмөрийн баатруудаа хүндэтгэе” гэрээг MNB, “Газар тариалангийн салбарын үйл ажиллагааг сурталчлах, тариаланчид дуулж байна” 54 удаагийн нэвтрүүлгийг Талын Монгол телевиз, “Газар тариалангийн салбарын дэвшил, техник, технологийн дэвшил” баримтат кино, 14 удаагийн нэвтрүүлгийг UBS телевизтэй дүгнэж акт, тэмдэглэл үйлдэн санхүүжүүлэв.	
31	4.5. Хамгаалагдсан хөрсний аж ахуй эрхлэгчдийг харилцан туршлага судлуулах, гидропоник орчинд ургуулах арга, технологи нэвтрүүлэх, аймаг, орон нутагт үзүүлэх сургалт зохион байгуулах;	2018 - 2022		<p>ХХХНЭЗӨМС төслийн хүрээнд олон улсын зөвлөх Лианг өвөл болон зуны хүлэмжийн онцлог, технологи, “Уур амьсгалын өөрчлөлтөд хүнсний ногоо үйлдвэрлэгчдийн дасан зохицох чадавхыг бэхжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга зам” сэдэвт сургалтаар хүлэмжинд хүнсний ногоо тарих чиглэлээр олон улсын туршлагын талаар мэдээлэл хийж, Монгол улсын цаг уурт тохиромжтой хүлэмжийн талаар зөвлөгөө өгсөн. Төслийн өвлийн хүлэмж барих Сэлэнгэ аймгийн Ерөө суманд агропарк барих 3 га газартай танилцаж, сумдын ногоочдын бүлгийн гишүүдтэй уулзаж, хүлэмжинд тарих хүнсний ногооны талаар мэдээлэл авч, зөвлөмж өгч ажилласан. Төв аймгийн “Атарын шим” ХХК-ий хүлэмжид “Хүлэмжийн тариалалтын үед гарах хөнөөлт организмтой тэмцэх тухай үзүүлэх сургалтанд сумдын газар тариалан хариуцсан мэргэжилтэнг хамруулсан. Сургалтын үеэр химийн бодисын хэрэглээг багасгах зорилгоор хүлэмжийг хортон шавьжны эсрэг наалдуулагч цаас ашиглах, таримлын өвчний эсрэг биологийн бэлдмэл ашиглах зэрэг аюулгүй аргыг хэрхэн хэрэглэх тухай үзүүлэх сургалт зохион байгуулсан. Говьсүмбэр аймаг өвлийн хүлэмжид тариалалт хийх сонирхолтой 6 иргэний судалгаа гаргаж “Хүлэмж барих, арчлах, ажиллуулах” талаар арга зүйн зөвлөгөө, 6 ш гарын авлага өгөв. Өвлийн хүлэмж барих сонирхолтой иргэдийг талбайн сургалтад хамруулах зардал 480.0 мян төгрөгийг ОНХ-ийн санд тусгуулан шийдвэрлүүлсэн ба Төв аймгийн “Ногоон харш” өвлийн хүлэмжийн аж ахуйтай хамтран ажилласан. “Хүлэмжинд нарийн ногоо тариалах технологи, техник ашиглалт” сэдэвт сургалтыг ХААШУОҮНТ-ийн Борнуур дахь төвд 6 сард зохион байгуулж, Дархан-Уул аймгийн Хонгор, Орхон, Дархан, Төв аймгийн Борнуур, Баянчандмань, Баянцогт, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Баруунхараа, Баянгол, Шаамар сумдын 54 ногоочинг хамруулаа. “Хүлэмж барих, хүлэмжинд нарийн ногоо тариалах технологи” сургалтыг Ховд аймгийн Дарви суманд хийж 25 ногоочинг хамруулсан.</p>	100%
32	4.6. Усалтын систем, усалгааны тоног төхөөрөмжийн ашиглалт, таримлын ус хэрэглээ, технологийн талаар хүнсний ногоо тариалагчдад зориулсан сургалт зохион байгуулах, сурталчилгаа хийх;	2018 - 2022		<p>“Ухаалаг усалгаа ургацын амжилт” сэдэвт сургалтыг Дархан-уул аймагт 60 ногоочин, Тогтвортой ХАА-н төслийн хүрээнд “Хүнсний ногооны зохистой дадал, усалгаа ба норм” сургалтыг Зүүн бүсийн аймгуудын 150 ногоочид, “Уур амьсгалын өөрчлөлтөд гэсвэртэй, тогтвортой ногооны аж ахуй эрхлэх олон улсын технологи туршлага нэвтрүүлэх” сургалтыг Дархан-уул аймагт 9 дүгээр сард ХХХНЭЗӨАС төслийн зорилтод 4 сумын ногоочдын бүлгүүдийн 80 хүнд зохион байгуулсан.</p>	100%
33	4.7. Бага, дунд оврын техникийн ашиглалт, зориулалт, шатахуун	2019 - 2022		<p>ХХААХҮЯ, Герман-Монголын хамтын ажиллагааны Тогтвортой хөдөө аж ахуй төслийн нэгжтэй хамтран хүнсний ногооны үйлдвэрлэл</p>	70%

	зарцуулалт, бүтээлийн норм, технологийн сургалтыг танхимд болон талбайд зохион байгуулах;				эрхлэгчдэд зориулсан “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариалангийн технологи” сэдэвт онол үйлдвэрлэлийн бага хурлыг 11 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд нийтдээ 110 гаруй тариаланчдыг хамруулан нийслэл хотод зохион байгуулав.	
34	4.8. Ногоочдыг сайн дураараа зохион байгуулалтад оруулж, ургацаа төв суурин газарт борлуулах ажлыг мэргэжлийн холбоодын оролцоотой зохион байгуулж, арга зүйн сургалт, сурталчилгаа хийх;	2018 - 2022			Монгол ногоо төслийн хүрээнд жишиг гудамжны загвар 29 өрх үрсэлгээ бойжуулах, зах зээлд ногоо нийлүүлж борлуулах зорилготой дулаалгатай хүлэмж барьж ашиглаж эхэлсэн ба нийт 3,824м2 талбайд 13 нэр төрлийн ногоо тарьсан. 2019 онд 9 загвар өрх төсөлд хамрагдаагүй 45 өрхөд зөвөлгөө өгч тэдгээр өрхүүд нь нийт 1,683м2 талбайд ногоо тарьж, 2,993 кг ургац хураан авсан. Секим төслийн хүрээнд “Экологижсон тариалангийн үйлдвэрлэлийн технологи” сургалтыг Төв аймгийн Сүмбэр сумын Од Сүмбэр, Арвижих, Бургас бүлгийн ногоочид, Сүмбэр сумын тариаланчид, Жаргалант сумын Оргилох заандууд хоршоо, “Жаргалант” бүлгийн ногоочид, усалгааны гудамж дагасан айл өрх, бүлгүүдийн төлөөлөл нийт 60 хүнийг хамруулж 2 өдрийн танхимын болон дадлагын сургалтыг зохион байгуулсан, “Хүнсний ногооны үр ашиг, үр үрсэлгээ, хүлэмж, хөрс боловсруулалт” сургалтад 270 хүн, “Цэцэрлэгийн хүүхдийн хоол тэжээл”-ийн сургалтад 356, “үлэг бэхжүүлэх, чадваржуулах” сургалтад 305 ногоочин, “хүнсний ногоог даршлах, нөөшлөх сургалтад 93 хүн хамрагдав.	100%
35	4.9. Дотооддоо үйлдвэрлэх шим болон биологийн бордоог хэрэглэх, хөрсний үржил шимийг сайжруулах, хашаажуулах технологийн сургалтыг бүсчлэн зохион байгуулах;	2019 - 2022			Дархан-Уул, Булган, Сэлэнгэ, Төв, Өвөрхангай, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй эрхлэгчид, дээрх аймгуудын газар тариалан хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан “Ургамал хамгаалал, хөрсний үржил шимийн менежмент” сургалтыг НҮБ-ын ХХААБ-аас санхүүжүүлж буй “Монгол ногоо” төслийн 4 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн багтай хамтран 2 удаа зохион байгуулсан ба сургалтад нийт 130 хүн хамрагдсан. Монгол-Герман улсын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн баг, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран 2019 оны 06 сарын 28-ны өдөр Дархан-уул аймагт “Тариалангийн талбайн хөрсний менежмент бордох технологи” сэдэвт сургалтыг 06 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан. 2019 онд Орхон аймгийн Жаргалант суманд 15.0 км тариалангийн талбайн хашааг барих ажлыг зохион байгуулсан ба нийт 130 иргэн, аж ахуй нэгжийн 98.8 га талбайг хамруулсан.	100%
36	4.10. Хүнсний ногооны түгээмэл өвчин, хортон шавьж, хог ургамлыг таних зорилго бүхий каталогийг хэвлүүлэн түгээх, хөнөөлт организмтай хүн, мал, амьтан, байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэх технологийн сургалт, семинарыг зохион байгуулах;	2018 - 2022			“Зүүн бүсийн Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын тариалангийн талбайн хөнөөлт организмын тархалт, зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох, судалгаа хийх, тэмцэх арга хэмжээг боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд хөнөөлт организмтой тэмцэх заавар, зөвлөмж 100 ш, зурагт хуудас 100 ш, хөнөөлт организмын талаарх каталог 100 ш хэвлүүлэн хөдөө аж ахуйн зохистой дадал, ургамал хамгааллын цогц аргын талаарх сургалтын үеэр тараасан.	100%
37	4.11. Борлуулалтыг дэмжих, бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор “Алтан намар” үзэсгэлэн-худалдааг бүх сум, дүүрэг, хороодод зохион байгуулж, орон нутагт	2018 - 2022			“Алтан намар-2019” үзэсгэлэн худалдаанд Мишээл экспо худалдааны төвд 16 аймгийн 36 сумын нийт 280 гаруй ногоочин, 6 аж ахуйн нэгж, 12 хоршоо, “Монгол ногоо”, Хоршоолсон хэлбэрээр хүнсний ногоо эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах”, “Адра”, “Каритас	100%

туршлага солилцох, үзүүлэх сургалт хийх.			<p>чех”, “Секим” төсөл, ХААИС-ийн Агробиологийн их сургууль, ХААШУОУНТ, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоо, Хүлэмжийн холбоо, Ногоочдын холбоо зэрэг ТББ-д 40 гаруй нэр төрлийн хүнсний ногоо, төмс 970 тн, 8 нэрийн таримал болон байгалийн жимс, жимсгэнэ, 8 нэрийн гоёл чимэглэлийн мод бутны суулгац, 6 нэр төрлийн ногооны үр, 60 гаруй нэрийн эмийн ургамал, 20 нэрийн тасалгааны цэцэг зэрэг бүтээгдэхүүнээр оролцож нийт 1.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Нийслэлийн 5 дүүргийн 70 гаруй цэгт 6 аймгийн 600 гаруй ногоочид 8 дугаар сарын 25-аас 9 дүгээр сарын 20 хүртэл 750 тн төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ борлуулж 1.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Үзэсгэлэнгийн үеэр ХААИС-ийн Агробиологийн их сургуулийн экспресс лаборатори ажиллуулан 300 гаруй ургамлын гаралтай дээж бүтээгдэхүүнд шинжилгээ хийж гэрээ байгуулсан захиалагч ХХААХҮЯ, ногоочид болон хэрэглэгчдэд шинжилгээний хариуг танилцуулан эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын талаас нь зөвлөгөө өгч ажиллав. Мөн 21 аймаг 8-9 дүгээр саруудад аймгийн төвүүддээ "Ургацын баяр" нэгдсэн худалдаа, борлуулалтыг дэмжиж ажилласан байна. Хэнтий, Өмнөговь, Дорнод, Дархан-уул, Увс, Ховд аймгууд санаачлага сайтай, олныг хамруулан ажилласан байна.</p>	
Зорилт-4-ийн дундаж үнэлгээ				94.5%